

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/264/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: З.Золбоо Утас: 7036-2442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. Аудитын тайлан	13-16
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Л. ЗОРИГТБААТАР ТАНАА

2023.02.17 № СЭА-2023/264/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86.1 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 13.9 хувиар хэмнэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 85.8 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 9 арга хэмжээний зардал эзэлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	863,250,105.0	1,057,707,370.0
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	367,469,160.0	579,519,210.0
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	61,381,215.0	84,076,400.0
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	281,008,130.0	199,898,660.0
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	37,318,500.0	119,085,000.0
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	116,073,100.0	66,796,100.0
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	-	8,332,000.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,496,250.0	1,350,640.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	864,746,355.0	1,059,058,010.0
51210	Өмнөх үеийн үр дүн	864,746,355.0	864,746,355.0
51220	Тайлант үеийн үр дүн	-	194,311,655.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>864,746,355.0</b>	<b>1,059,058,010.0</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан


төгрөгөөр			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>676,613,000.0</b>	<b>1,326,523,236.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,172,000.0</b>	<b>76,019,036.0</b>
1200	Өмчийн орлого	35,172,000.0	76,019,036.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,172,000.0	76,019,036.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	35,172,000.0	76,019,036.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>641,441,000.0</b>	<b>1,250,504,200.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	641,441,000.0	1,250,504,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,315,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	626,126,000.0	1,250,504,200.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>811,578,175.0</b>	<b>1,132,211,581.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,578,175.0	1,132,211,581.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,548,900.0	3,210,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,358,900.0	3,210,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,250,000.0	3,210,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,900.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,000.0	4317143998
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,190,000.0	МНОА0065 9055436
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	809,029,275.0	1,129,001,581.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,172,000.0	74,759,036.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,172,000.0	59,639,036.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,120,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,566,100.0	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,566,100.0	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	520,851,098.0	692,522,860.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	520,851,098.0	692,522,860.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	239,440,077.0	361,719,685.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	239,440,077.0	361,719,685.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(134,965,175.0)	194,311,655.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(134,965,175.0)	194,311,655.0

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	676,613,000.0	1,328,019,486.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,172,000.0	77,515,286.0
1200	Өмчийн орлого	35,172,000.0	77,515,286.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,172,000.0	77,515,286.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	35,172,000.0	76,019,036.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	1,496,250.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	641,441,000.0	1,250,504,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	641,441,000.0	1,250,504,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,315,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	626,126,000.0	1,250,504,200.0
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	451,461,425.0	502,542,735.0
145	Бусад орлого (олз)	451,461,425.0	502,542,735.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,128,074,425.0	1,830,562,221.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,128,074,425.0	1,830,562,221.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,548,900.0	3,210,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,358,900.0	3,210,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,250,000.0	3,210,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,900.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,000.0	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,000.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,125,525,525.0	1,827,352,221.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,668,250.0	76,109,676.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,668,250.0	60,989,676.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,120,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,566,100.0	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,566,100.0	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	520,851,098.0	692,522,860.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	520,851,098.0	692,522,860.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	554,440,077.0	1,058,719,685.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	554,440,077.0	1,058,719,685.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(451,461,425.0)	(502,542,735.0)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	451,461,425.0	502,542,735.0
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	451,461,425.0	502,542,735.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	451,461,425.0	502,542,735.0



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	төгрөгөөр	
				Бусад	Дүн
1	<b>2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	-	<b>999,711,530.0</b>	-	<b>999,711,530.0</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	999,711,530.0	-	999,711,530.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	(134,965,175.0)	-	(134,965,175.0)
6	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>864,746,355.0</b>	-	<b>864,746,355.0</b>
7	<b>2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	-	<b>864,746,355.0</b>	-	<b>864,746,355.0</b>
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	864,746,355.0	-	864,746,355.0
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-	194,311,655.0	-	194,311,655.0
12	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>1,059,058,010.0</b>	-	<b>1,059,058,010.0</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Тайлант он
3	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>449,965,175.00</b>	<b>502,542,735.00</b>
30	<b>Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого</b>	<b>-1,496,250.00</b>	<b>1,350,640.00</b>
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх	-1,496,250.00	1,350,640.00
32	<b>ЗГ-ын гадаадын төслийн зээл</b>	<b>451,461,425.00</b>	<b>501,192,095.00</b>
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	451,461,425.00	501,192,095.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>451,461,425.00</b>	<b>502,542,735.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	451,461,425.00	502,542,735.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан




Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,263,061,800.0	1,137,948,721.0	125,113,079.0	90.1
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,263,061,800.0</b>	<b>1,137,948,721.0</b>	<b>125,113,079.0</b>	<b>90.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,263,061,800.0</b>	<b>1,137,948,721.0</b>	<b>125,113,079.0</b>	<b>90.1</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,263,061,800.0	1,137,948,721.0	125,113,079.0	90.1
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,500,000.0	3,210,000.0	1,290,000.0	71.3
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,500,000.0	3,210,000.0	1,290,000.0	71.3
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,500,000.0</b>	<b>3,210,000.0</b>	<b>1,290,000.0</b>	<b>71.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,500,000.0</b>	<b>3,210,000.0</b>	<b>1,290,000.0</b>	<b>71.3</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,500,000.0	3,210,000.0	1,290,000.0	71.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.0	3,210,000.0	1,290,000.0	71.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.0	3,210,000.0	1,290,000.0	71.3
3	<b>ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл</b>	<b>1,258,561,800.0</b>	<b>1,134,738,721.0</b>	123,823,079.0	90.2
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,258,561,800.0</b>	<b>1,134,738,721.0</b>	123,823,079.0	90.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,228,561,800.0	1,058,719,685.0	169,842,115.0	86.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,228,561,800.0	1,058,719,685.0	169,842,115.0	86.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,228,561,800.0	1,058,719,685.0	169,842,115.0	86.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,228,561,800.0	1,058,719,685.0	169,842,115.0	86.2
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,000,000.0	76,019,036.0	(46,019,036.0)	253.4
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,263,061,800.0</b>	<b>1,137,948,721.0</b>	125,113,079.0	<b>90.1</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,233,061,800.0	1,061,929,685.0	171,132,115.0	86.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	1,233,061,800.0	1,061,929,685.0	171,132,115.0	86.1
115	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого	30,000,000.0	76,019,036.0	(46,019,036.0)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2022 оныг “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах” хүрээг өргөжүүлэн хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:



- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх,
- Хүн амын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
- Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатны хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын “Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар”-аас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/289 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 194,311.6 мянган төгрөгөөр буюу 22.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	864,746.4	1,059,058.0	194,311.6
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>864,746.4</b>	<b>1,059,058.0</b>	<b>194,311.6</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	864,746.4	1,059,058.0	194,311.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>864,746.4</b>	<b>1,059,058.0</b>	<b>194,311.6</b>

Авлага дансны үлдэгдэл 1,059,058.0 мянган төгрөг болж 194,311.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 697,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэг олгосон, 2022 оны эцэст 1,350.6 мянган төгрөгийг төсөвт

татуулсан зэргээр нэмэгдэж, дэмжлэгийн эргэн төлөлт 502,542.7 мянган төгрөг болон өмнөх онд төсөвт төвлөрүүлсэн 1,496.3 мянган төгрөгийг буцаан авсан зэрэг буурсан гүйлгээнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,059,058.0 мянган төгрөг болж 194,311.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.



### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сангийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн орлого 30,000.0 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 341,332.3 мянган төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас олгох санхүүжилт 856,234.2 мянган төгрөг зэрэг нийт 1,227,566.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөж, урсгал үйл ажиллагааны зардалд 856,234.2 мянган төгрөгийг зарцуулж, 371,332.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын нийт эх үүсвэрийг 47,937.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,275,504.2 мянган төгрөг /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас олгох санхүүжилтийг 1,245,504.2 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн орлогыг 30,000.0 мянган төгрөг/, урсгал үйл ажиллагааны зардал / 856,234.2 мянган төг /-ыг 419,270.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,275,504.2 мянган төгрөг болгон тус тус өөрчлөн баталсан байна.

Төсвийн төслийн үйл ажиллагааны урсгал зардлын саналын өсөлт нь дараах хөтөлбөр, арга хэмжээний зардлуудыг нэмж баталснаас голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн зардал 18,926.0 мянган төгрөг,
- Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн зардал 144,800.0 мянган төгрөг,
- Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал 38,800.0 мянган төгрөг,
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардал 12,850.0 мянган төгрөг,
- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг 32,459.0 мянган төгрөг,
- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардал 98,960.0 мянган төгрөг.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 12,442.4 мянган төгрөгөөр бууруулж 1,263,061.8 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 76,019.0 мянган төгрөг орж улсын төсвийн дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,233,061.8 мянган төгрөгийг улсын төсвөөс авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,061,929.8 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь нийт зардлыг 171,132.1 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн үйл ажиллагаа	4,500.00	3,210.00	1,290.00	71.3
2	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	171,871.00	158,158.30	13,712.70	92.0
3	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	572,036.80	507,485.50	64,551.30	88.7
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	42,048.00	24,744.50	17,303.50	58.8
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	149,960.00	148,417.00	1,543.00	99.0
6	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	6,600.00	6,340.00	260	96.1
7	Ажилд зуучлах үйлчилгээ	5,600.00	5,443.60	156.4	97.2
8	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	239,556.00	170,712.90	68,843.20	71.3
9	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	40,890.00	37,418.00	3,472.00	91.5
	<b>Дүн</b>	<b>1,233,061.8</b>	<b>1,061,929.80</b>	<b>171,132.10</b>	<b>86.1</b>


Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд санхүүгийн дэмжлэгийн 502,542.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 811,578.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,173.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/1613 дугаар албан бичгээр харьяа газруудад чиглэл өгч ажилласан байна. Тус чиглэлийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан

сумдын мэргэжилтнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг “E-work” албан хэрэг хөтлөлтийн программаар дамжуулан, бичиг хэргийн зардлыг хэмнэж ажилласан бөгөөд жилийн эцэст өр төлбөргүй тайлагнагдсан байна.



#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 166-г хугацаанд нь мэдээлсэн бол таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээ 15,120.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 29 иргэнд олгосон нийт 53,193.9 мянган төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлж, санг хохиролгүй болгох арга хэмжээ авах, ахмад

мэргэжилтний зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, тайланг үнэн зөв гаргуулсны үндсэн дээр санхүүжилтийг олгож байх 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилт 86.2 хувьтай байна.



**Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт**

/мянган төгрөгөөр/ 4317143998  
A0065 9055436

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	53,193.9	2	45,843.9	86.2
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>53,193.9</b>	<b>2</b>	<b>45,843.9</b>	<b>86.2</b>

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хугацаа хэтэрсэн дэмжлэгийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлж, 12 иргэний 20,394.8 мянган төгрөгийн зээлийг бүрэн барагдуулж, 7 иргэний 25,395.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй зээлдэгчтэй холбоотой шүүхийн шийдвэр гаргуулан, шийдвэр гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажилласан бол үлдсэн 5 иргэний /нас барсан, хэтэрт байгаа, бичиг баримтын бүрдэл дутуу, хаяг дээрээ байхгүй-2 гэх шалтгаанаар/ 7,350.0 мянган төгрөгийн зээлд ажиллагаа явагдаагүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 314 иргэний, 1,057,707.4 мянган төгрөгийн эргэн төлөгдөх дэмжлэг бүртгэлтэй байна. Үүнээс:

- Эргэн төлөгдөх графикт хугацаа дуусаагүй боловч 1-3 сараар хугацаа хоцроосон 98 иргэний 138,679.5 мянган төгрөгөөс 88 иргэний 128,903.2 мянган төгрөгийн зээлд графикийн зөрчлийг арилгуулах “Мэдэгдэл” хуудсыг биечлэн хүргүүлж, 9,776.3 мянган төгрөгийн зээлтэй 10 иргэнд утсаар мэдэгдэж ажилласан байна.
- Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх графикт хугацаа дууссан 37 иргэний 123,031.1 мянган төгрөгийн зээл байгаагаас 98,844.7 мянган төгрөгийн зээлийг төлүүлэхээр 26 иргэнийг шүүхэд шилжүүлж шийдвэр гаргуулсан бол ковид 19 цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагаа нь зогссон 11 иргэний 24,186.4 мянган төгрөгийн зээлийн хугацааг 6 сараар сунгасан байна.

Санхүүгийн дэмжлэгийн график зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгуулж, төлөлтийг графикийн дагуу төлүүлэхгүйгээс шалтгаалан цаашид хугацаа хэтэрсэн зээлдэгчийн тоо, үлдэгдэл нэмэгдэх эрсдэлтэй байна.


2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

2020 оны 6 дугаар сард ХХҮЕГ нь Сангийн яамтай зөвшилцсөний дагуу тус агентлагийн харьяа газар, хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн дэд сангуудын санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг нэмэлт санхүүжилтийн дансаар

дамжуулан зарцуулах чиглэл өгсөн байна. Үүний дагуу хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, арга хэмжээний нэмэлт данс нээж, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, зарцуулалтыг тус дансаар дамжуулан гүйцэтгэсэн байна.

Өөрөөр хэлбэл үндсэн үйл ажиллагааны төсвийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, зарцуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.4 дэх “Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө”, 47.1.5 дахь “Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого” гэсэн заалттай нийцэхгүй байна.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 7,278.5 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

#### 1.Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 7,278.5 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Дээрх зөрчил нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
<b>Дүн</b>													

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Төлбөрийн цахим баримтыг үндэслэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн	1	7,278.5					1	7,278.5				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,278.5</b>					<b>1</b>	<b>7,278.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	15,120.0						1	15,120.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>15,120.0</b>						<b>1</b>	<b>15,120.0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>15,120.0</b>						<b>1</b>	<b>15,120.0</b>